



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.08.07 №

994

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ард түмний олонхын засаглал намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл /бие даан нэр дэвшигч/ нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн боловсруулж санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа 2050", Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль,

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ард түмний олонхын засаглал намаас Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Ард түмний олонхын засаглал намын сонгуулийн мөрийн хөтөлбөр 1.3...хуудас/-ийг хавсаргав.

Хувийг Нийслэлийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Ард Түмний Олонхийн Засаглал Намын
2024 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн
Бага хурлаар батлав.



“АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ” НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР


“АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ” Нам нь Монгол Үндэстний Үндэсний язгуур эрх ашиг нөгдөл, шашин шүтлэг, тусгаар тогтнол, уламжлалт төрийн хууль цааз, ёс суртахууны хэм хэмжээ, соёл, нийт монгол угсаатны зан заншлаа хадгалан хамгаалсан, хүчирхэгжүүлэн хөгжүүлэх үзэл санааг сууриа болгосон консерватив талын үзэл баримтлалтай нам тул Монгол Улсын Их Хурлын сонгуульд өргөн барьсан мөрийн хөтөлбөрийн хүрээнд дараах бодлогыг энэ сонгуульд хэрэгжүүлэхээр мөрийн хөтөлбөр болгож байна.

1. Үндэсний үзэл санааг хэрэгжүүлэх бодлого

- 1.1. Монгол Улс Монголын ард түмний язгуур эрх ашгийг хамгаас эрхэмлэн дээдэлнэ.
- 1.2. Иргэд, хүүхэд залуучууддаа эх орон, эх түүх, үндэсний хэл, бичиг, соёл уламжлалаараа бахархах дээдлэх ёс суртахууныг төлөвшүүлэх, үндэсний сэтгэлгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.3. Нийгмийн хөгжлийн хамгийн том саад болсон авлигын эсрэг, нийгэмд авлигыг, авлигачдыг үл тэвчих үзэл суртлын ажлыг явуулж, үе шаттай өрнүүлнэ.
- 1.4. Хөдөлмөрч, бүтээлч хандлагыг иргэдэд төлөвшүүлж, хариуцлага, сахилга бат, дэг журам, хуульт ёс, хяналт бүхий боломжийг бий болгож иргэддээ олгоно.
- 1.5. Боловсролын системд үндэсний түүх, хэл, соёл, уламжлалаараа хойч үеэ сурган хүмүүжүүлэхэд онцгой анхаарч бүх шатны сургуульд түүхийн хичээлийг оруулж шалгалт авдаг болгох, үндэсний боловсон хүчнийг хэрэгцээ шаардлагадаа тохирсон хэмжээнд бэлтгэх бодлого боловсруулна.

2. Шударга ёсыг бэхжүүлэх бодлого

- 2.1. Сонгуулийн Ерөнхий Хороонд улс төрийн намууд, олон нийтийн байгууллага болон нам бус иргэдийн төлөөллийг оролцуулах, хяналт тавих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хууль санаачилна.
- 2.2. Сонгуулийн дүнг зөвхөн гараар тоолох хяналтын системийг дэмжих эрх зүйн орчныг бий болгоно.
- 2.3. Авлигатай нэр холбогдож, ял шийтгүүлсэн этгээдийн төрийн албанд ажиллах, сонгуульд оролцох эрхийг хязгаарлана.
- 2.4. Ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн зохицуулалт хийнэ.
- 2.5. Төрийн албаны албан хаагчдын үйл ажиллагаа, ёс зүйд хяналт тавьж, хууль зөрчсөн, ёс зүйн алдаа гаргасан тохиолдолд улс төрийн хариуцлага хүлээж, огцордог зэрэг соёл, хандлагыг төлөвшүүлнэ.
- 2.6. Төрийн албаны бүх томилгоонд улс төрийн албан хаагч, УИХ-ын гишүүдийн нөлөөллийг хуулиар хязгаарлана.
- 2.7. Улсын Их хурлын гишүүдээс нийслэлийн, орон нутгийн төсөв, санхүү хуваарилах ажиллагаанд оролцох эрх мэдлийг хязгаарлаж, Засгийн газраас өргөн мэдүүлсэн улсын төсөв дэх зардлын хэмжээг нэмэхгүй байх хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.
- 2.8. Мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан төрийн байгууллагын үйлчилгээнд цахим технологи нэвтрүүлж, хүнд суртал, авлига хамгийн их үүсгэж буй үйлчилгээнүүдийг цахимжуулна. (цахим гааль, цахим татвар, цахим иргэний бүртгэл, цахим шүүх, цахим газрын харилцаа, цахим эрүүл мэнд, цахим боловсрол гэх мэт)
- 2.9. Хүнд сурталгүй төрийн үйлчилгээ нэвтрүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулж, төрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.
- 2.10. Мэдээллийн аюулгүй байдлын, Цахим болон тоон гарын үсгийн, Мэдээллийн сангийн, Хувь хүний мэдээллийн аюулгүй байдлын зэрэг цахим засаглалыг хөгжүүлэхэд шаардагдах хууль тогтоомжийг батална.
- 2.11. Их өгөгдөлд суурилсан нийслэлийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж иргэн, төр, бизнесийн байгууллагууд цахимаар мэдээлэл солилцох, ашиглах техник технологийн дэд бүтцийг тогтмол сайжруулна.



[Handwritten signature]

- 2.12. Цахим ардчиллыг хөгжүүлж, нийслэлийг хөгжүүлэх бодлого, бодлого төлөвлөгөө, шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих зорилготой хуулиар заасан хугацаа тогтоож, цахимаар оролцох боломжийг өргөжүүлнэ.
- 2.13. Нийслэлийн төрийн байгууллагуудад хандсан иргэдийн өргөдөл, хүсэлтийг шуурхай шийдэж, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг цахим хэлбэрээр хянадаг болно
- 2.14. Нийслэлийн газарзүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэгцээнд хуваарласан газар олголт ашиглалтын талаарх мэдээллийг ил тод болгоно.
- 2.15. Засгийн газрын тусгай сангуудаас нийслэлд хуваарлигдаж байгаа хөрөнгөнөөс иргэ хувийн хэвшлийн үйл ажиллагааг иргэд, дэмжихэд чиглэсэн бодлогыг дэмжиж олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлэхэд анхаарч ажиллана.


3. МЭРГЭШСЭН, ЁС ЗҮЙТЭЙ ТӨРИЙН АЛБА

- 3.1. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 3.2. Төр, иргэний нийгэм болон бизнесийн байгууллагад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх хандлага төлөвшүүлж, авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх мэдээллийг урамшуулах эдийн засгийн болон бусад хөшүүргийг бий болгоно.
- 3.3. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.
- 3.4. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнгээс үл хамааран чадахуйн болон шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитоор хэрэгжүүлнэ.
- 3.5. Төрийн албан хаагчдыг мэргэжлийн салбарт ажиллуулахдаа дээрээс шууд томилдог босоо тогтолцоог өөрчилж, төр засгийн дунд, доод шатны байгууллагуудад ажил мэргэжил албан тушаал, ажилласан жил, туршлага, гавъяа зүтгэлийг нь харгалзан үзэж томилдог байсан итгэл үнэмшлийн зарчмыг сэргээнэ.
- 3.6. Бүх ард түмний нийтээр мөрдөх улс төрийн ёс зүйн хуулийг санаачилна. Хүний эрх, эрх чөлөөний асуудлыг онцгой анхаарч, зөрчигдөж буй нөхцөл шалтгааныг судалж, хяналтын механизм, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө үйл ажиллагаа явуулна.
4. Хүний хөгжлийн бодлого

- 4.1. Өрхийн бичил бизнесийг дэмжиж, хүүгүй, барьцаагүй санхүүгийн дэмжлэг үзүүлэх бодлогыг барьж ажиллана.
- 4.2. Гарааны бизнес эрхлэгч оюутан, залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 4.3. Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, санхүүгийн үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.

5. ЭРҮҮЛ ИРГЭН

- 5.1. Үндэсний оношилгооны чадавхыг дээшлүүлж, иргэн бүр эрүүл мэндийн бүрэн оношилгоонд жил бүр заавал хамрагдах тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.2. Иргэдийн эрүүл мэндийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, орон нутгийн болон бүх шатлалын эмнэлгүүдийн оношилгоо, мэдээллийг дотоодод болон олон улсад цахимаар солилцох тогтолцоог бүрдүүлнэ.
- 5.3. Эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээ, эмийн хөнгөлөлт авах зэрэг цахим эрүүл мэндийн системийг бүрэн нэвтрүүлж, эмчлүүлэгчийн нууцлалыг хангаж, зардал, хүлээгдэл, чирэгдлийг бууруулна.
- 5.4. Хавдар, зүрх судасны өвчлөлийг эрт илрүүлэх оношилгоо, эмчилгээний шинэ арга зүй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэн эх орондоо бүрэн эмчлэх боломж бүрдүүлж, гадаад улсад оношилгоо, эмчилгээ хийлгэх иргэдийн урсгалыг эрс бууруулна.
- 5.5. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, даатгуулагч үр шимийг хүртэх боломжийг нэмэгдүүлнэ.



[Handwritten signature]

- 5.6. Яаралтай тусламжийн үндэсний сүлжээний чадавхыг дээшлүүлж, түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, шаардлагатай үеийн нисдэг тэрэг ашиглалтыг нэмэгдүүлнэ.
 - 5.7. Мансууруулах бодис хэрэглэгч, донтогч нарыг эмчлэх, эрүүл мэнд, сэтгэл зүйн засал, нийгмийн тусламж үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх төв байгуулна.
 - 5.8. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн чадавхыг сайжруулж, хавдар, зүрх судас, гэмтэл согог, эх нялхсын эрүүл мэндийн үйлчилгээний чанар, техник, тоног төхөөрөмжийг сайжруулж, иргэд орон нутагтаа үндэсний түвшний тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.
 - 5.9. Сумдын эмнэлгийг халуун, хүйтэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно.
- Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй болон ахмад настнуудын эмчилгээ, асаргаа, сувилгаа зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана

6. ҮНДЭСНИЙ ДЭД БҮТЦИЙН СҮЛЖЭЭ

- 6.1. Газар хөдлөлт, байгалийн гамшгийн эрсдэл аюулыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд барилга, байгууламж, орон сууцыг бүртгэлжүүлэх, ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг шинэчлэх, хүчитгэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 6.2. Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлуулж, эрсдэлтэй бүсүүдэд амьдардаг өрхийн тоог бууруулна.
- 6.3. Нийслэл хотын эрчим хүч дулааны сүлжээний ашиглалтад судалгаа хийж шаардлагатай байгаа цэгүүдэд дээрх сүлжээний өргөтгөлийн ажлуудыг хэрэгжүүлнэ.
- 6.4. Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах хаягдлыг багасгах ногоон үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг дэмжинэ.
- 6.5. Байгаль орчинд ээлтэй сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 6.6. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ.
- 6.7. Эрчим хүчний үйлдвэрлэл, аж үйлдвэрийн технологийг шинэчлэн, алдагдлыг бууруулах, үнийн бодлогыг оновчтой болгож, сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 25 хувьд хүргэнэ.
- 6.8. Эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи ашиглан барилгын дулааны алдагдлыг бууруулна.

7. Хууль санаачлах

7. Үндэсний эдийн засаг дахь стратегийн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн болон объектуудад тавих төрийн хяналтыг сайжруулж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн алдаа завхралыг арилгах хуулийг санаачилна.
 - 7.1. Архи, согтууруулах ундаа, тамхи гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортод хяналтыг сайжруулж, өндөр татвар оногдуулах замаар хязгаарлана. Нийт иргэдийнхээ эрүүл мэнд, цус өйртөлтын өвчний эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.
 - 7.2. Үнэт цаасны зах зээлийн хөгжил дэвшлийг болон иргэд, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцдог орчин үеийн системийг дэмжинэ.
 - 7.3. Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд залуучуудыг хөдөө орон нутагт ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд явуулж буй засгийн газрын бодлого шийдвэрүүдийг дэмжинэ.
 - 7.4. Бэлчээрийн мал аж ахуйг хамгаалах, уул уурхайн бодлогыг зөв хөгжүүлэх талаар бодлого дэвшүүлж, малчдын хүсэл, санаачлагыг тусгаж дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
 - 7.5. Улсын Их Хурлаас баталсан улс орон даяар хэрэгжүүлэх "Алсын хараа -2050" урт хугацааны хөгжлийн бодлого, шийдвэр болон Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан асуудлуудыг дэмжиж ажиллах болно.

**ИХ МОНГОЛ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ СҮР ХҮЧИЙГ ҮҮРДИЙН ҮҮРД,
ҮЕИЙН ҮЕД САХИН ХАМГААЛТЯ АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ НАМ**



Handwritten signature